

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

| | |
|---|----|
| 1.Аудитын гэрчилгээ | 2 |
| 2.Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. Оршил | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 5 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 6 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 7 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл | 7 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 7 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 7 |
| 3.Менежментийн захидал | 8 |
| 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 9 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 9 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 10 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 11 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 12 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 13 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ИНЕГ-ЫН ХАРЬЯА СЭРГЭЭН
ЗАСАХ АМРАЛТЫН ДАРГА
Ж.АМАРСҮРЭН ТАНАА

2020.03.13 № 06/806
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,15,2; 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ж.Амарсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн он удаан жил болсон авлагыг барагдуулах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2; 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Удирдлага нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-наас 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 04/б/27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Амралт сувилалын таатай орчин бүрдүүлж, үйлчлүүлэгчдээ дээдлэн ажилтан бүрийнхээ амжилтаар бахархах манлайлагч хамт олон байх ” гэж тодорхойлжээ.

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын үйл ажиллагааны чиглэл нь амралт, сувиллын үйл ажиллагаа байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол
- Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019 оны 268 дугаар тогтоол

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Веритех” ХХК-ийн Veritech erp программ хангамж ашиглаж байна.

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,466.3 сая төгрөгөөс тооцон 14.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43.3 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, өглөг, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөг/ |
|---|----------------|-----------------|---------------|
| | | | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 5.7 | 10.5 | 4.8 |
| Авлага | 48.9 | 47.8 | (1.1) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 184.9 | 198.4 | 13.5 |
| Үндсэн хөрөнгө | 1,804.5 | 1,744.0 | (60.5) |
| Нийт хөрөнгө | 2,044.0 | 2,000.7 | (43.3) |
| Өр төлбөр | 5.9 | 43.5 | 37.6 |
| Эздийн өмч | 2,038.1 | 1,957.2 | (80.9) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 2,044.0 | 2,000.7 | (43.3) |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 4.8 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлого өссөнтэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 13.5 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал болон бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 60.5 сая төгрөгөөр буурсан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны А-5/1435 тоот тогтоолоор тавилга, эд хогшлын данснаас 1.4 сая төгрөг, программ хангамжийн данснаас 1.3 сая төгрөгийн хөрөнгийг тус тус акталжээ. Мөн Иргэний нисэхийн ерөнхий газрын шийдвэрийн дагуу 61.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 37.6 сая төгрөгөөр өссөн нь систем хоорондын өглөг төлөгдөөгүйгээс үүсэн байна.

2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зорилтын саналыг хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасныг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сэргээн засах амралт нь ИНЕГ-ын харьяаны байгууллага бөгөөд харьяалах дээд байгууллага нь 2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг 740.0 сая төгрөгийн орлоготой, 615.5 сая төгрөгийн санхүүжилттэй, 1,427.5 сая төгрөгийн зардалтай, 72.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталжээ.

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт нь 2019 онд 740.0 төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 771.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 104.2 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө 4.2 хувиар давж биелсэн нь үйлчилгээ, хоолны чанарыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр, халамжийн ерөнхий газраас зарласан “Ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх” тендерт шалгарч орлого нэмэгдсэнтэй холбоотой.

Нийт үйл ажиллагааны зардал 1,466.3 сая төгрөг бөгөөд өмнөх оноос 302.8 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс цалин хөлсний зардал 110.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 11.5 сая төгрөг, элэгдлийн зардал 49.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2019 онд өөрийн харьяа ИНЕГ-аас 615.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 771.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас төвлөрүүлэн, үйл ажиллагааны зардалд 1,466.3 сая төгрөг зарцуулснаар 79.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 горим, сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 11.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаа хэвийн байна гэж үзээд албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 11.1 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 14.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тусгагдсан 11.1 сая төгрөгийн авлага нь 9-с дээш жилийн насжилттай барагдаагүй авлага байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Өр, авлага төлөгдөхгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>239,516,331.18</u> | <u>256,755,597.84</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 5,714,773.57 | 10,541,386.87 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 4,204,607.04 | 15,026.00 |
| 31110 | Төгрөг | 4,204,607.04 | 15,026.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 878,274.53 | 10,526,360.87 |
| 3121 | Төгрөг | 878,274.53 | 10,526,360.87 |
| 31211 | Арилжааны банк дахь харилцах /ХХБ / | 860,974.53 | 5,889,809.55 |
| 31212 | Арилжааны банк дахь харилцах /ХААН/ | 17,300.00 | 4,636,551.32 |
| 31400 | Замд яваа мөнгөн хөрөнгө | 631,892.00 | |
| 33 | АВЛАГА | 48,917,638.03 | 47,800,155.11 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 622,352.00 | 934,323.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 26,914,766.03 | 26,306,154.03 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 3,800,000.00 | 1,974,658.08 |
| 335 | Бусад авлага | 17,580,520.00 | 18,585,020.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 17,580,520.00 | 18,585,020.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 184,883,919.58 | 198,414,055.86 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 2,503,040.14 | 3,289,105.38 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 18,273,590.26 | 22,771,967.25 |
| 354 | Хангамжийн материал | 164,107,289.18 | 172,352,983.23 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 26,290,194.06 | 25,730,921.34 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 137,817,095.12 | 146,622,061.89 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,804,510,026.45</u> | <u>1,743,972,802.51</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,804,510,026.45 | 1,743,972,802.51 |
| 392 | Биет хөрөнгө | 1,804,510,026.45 | 1,743,972,802.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,643,775,938.08 | 1,677,374,849.55 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,130,855.82) | (93,164,150.42) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 108,130,567.00 | 114,032,567.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (65,890,272.45) | (77,197,022.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 237,302,250.09 | 249,444,200.09 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (104,677,600.45) | (126,517,640.87) |
| 393 | Биет бус хөрөнгө | - | - |
| 39301 | Програм хангамж | 1,788,405.40 | 8,631,263.55 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,788,405.40) | (8,631,263.55) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>2,044,026,357.63</u> | <u>2,000,728,400.35</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>5,880,162.42</u> | <u>43,495,498.59</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 5,880,162.42 | 43,495,498.59 |
| 413 | Өглөг | 5,880,162.42 | 43,495,498.59 |
| 4136 | Бусад өглөг | 5,880,162.42 | 43,495,498.59 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 2,844,929.43 | 1,408,460.66 |
| 41364 | НДШ - ийн өглөг /ТӨҮГ/ | - | 3,872.23 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 3,035,232.99 | 42,083,165.70 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>2,038,146,195.21</u> | <u>1,957,232,901.76</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,038,146,195.21 | 1,957,232,901.76 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 15,951,000.00 | 14,315,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| 51102 | - хувийн | | |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 15,951,000.00 | 14,315,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,365,531,275.96 | 1,286,253,982.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 1,365,531,275.96 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,365,531,275.96 | (79,277,293.45) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 656,663,919.25 | 656,663,919.25 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>2,044,026,357.63</u> | <u>2,000,728,400.35</u> |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,337,688,033.54 | 1,387,069,093.17 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 738,662,808.70 | 771,524,827.93 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 738,662,808.70 | 771,524,827.93 |
| 120002 | Хүүгийн орлого | 1,203,759.42 | 941,811.66 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 737,459,049.28 | 770,583,016.27 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 599,025,224.84 | 615,544,265.24 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 599,025,224.84 | 615,544,265.24 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,163,531,221.53 | 1,466,346,386.62 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,163,531,221.53 | 1,466,346,386.62 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,163,531,221.53 | 1,466,346,386.62 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 421,458,167.49 | 532,160,473.48 |
| 210101 | Үндсэн цалин | 251,571,579.68 | 334,939,653.06 |
| 210102 | Нэмэгдэл | 98,136,587.81 | 116,080,820.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 71,750,000.00 | 81,140,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,515,701.22 | 65,495,509.93 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 49,515,701.22 | 65,495,509.93 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 96,807,742.99 | 108,356,758.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 92,518,857.98 | 99,126,441.85 |
| 210302 | Түлш, халаалт | 2,541,879.52 | 3,041,736.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,747,005.49 | 6,188,580.45 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 31,803,203.73 | 72,527,814.01 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,309,019.43 | 2,973,502.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 38,552,204.62 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,605,809.44 | 3,975,544.26 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 22,888,374.86 | 27,026,562.43 |
| 2105 | Нормативт зардал | 247,249,444.41 | 257,397,160.81 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | 245,257,444.41 | 255,683,258.08 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,992,000.00 | 1,713,902.73 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 52,140,932.95 | 32,253,790.77 |
| 210604 | Урсгал засвар | 52,140,932.95 | 32,253,790.77 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 200,500,577.12 | 284,561,243.81 |
| 210807 | Газрын төлбөр | | 18,565,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | 2,146,949.58 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ | 150,120,599.53 | 195,670,049.62 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 50,379,977.59 | 68,179,244.61 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,055,451.62 | 113,593,635.41 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 64,055,451.62 | 113,593,635.41 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 174,156,812.01 | (79,277,293.45) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 174,156,812.01 | (79,277,293.45) |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|-------------|--|--------------------------------|--------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,150,268,161.01</u> | <u>1,388,586,864.33</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 750,268,161.01 | 822,774,227.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 750,268,161.01 | 822,774,227.10 |
| 120009 | Бусад орлого | 215,925,625.11 | 167,534,516.68 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/ | 531,576,472.90 | 651,922,767.42 |
| 120015 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/ | 2,766,063.00 | 3,316,943.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 400,000,000.00 | 565,812,637.23 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 400,000,000.00 | 565,812,637.23 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 400,000,000.00 | 565,812,637.23 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>1,159,067,770.38</u> | <u>1,384,504,498.46</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,159,067,770.38 | 1,384,504,498.46 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,159,067,770.38 | 1,384,504,498.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 434,975,970.72 | 559,877,935.06 |
| 210101 | Үндсэн цалин | 434,975,970.72 | 362,657,114.64 |
| 210102 | Нэмэгдэл | | 116,080,820.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 81,140,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 124,722,923.21 | 169,115,660.36 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 124,722,923.21 | 169,115,660.36 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 98,431,085.00 | 105,217,407.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 98,431,085.00 | 99,126,441.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 6,090,965.15 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 330,592,939.97 | 401,563,110.28 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 330,592,939.97 | 401,563,110.28 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 170,344,851.48 | 148,730,385.76 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 44,251,936.12 | 64,114,199.43 |
| 210817 | Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/ | 1,469,817.00 | |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 124,623,098.36 | 84,616,186.33 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>(8,799,609.37)</u> | <u>4,082,365.87</u> |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 884,314.53 | 744,247.43 |
| 140007 | Хүлээн авсан хүүний орлого | 884,314.53 | 744,247.43 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>884,314.53</u> | <u>744,247.43</u> |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | ≡ | ≡ |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (7,915,294.84) | 4,826,613.30 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 13,630,068.41 | 5,714,773.57 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 5,714,773.57 | 10,541,386.87 |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Эдийн өмчийн бусад хэсэг | Нийт дүн |
|--|-----|-------------------------------------|-------------------------|--------------------------|-------------------------|
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 656,663,919.25 | 1,365,531,275.96 | 15,951,000.00 | 2,038,146,195.21 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 656,663,919.25 | 1,365,531,275.96 | 15,951,000.00 | 2,038,146,195.21 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | (1,636,000.00) | (1,636,000.00) |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | (79,277,293.45) | | (79,277,293.45) |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 656,663,919.25 | 1,286,253,982.51 | 14,315,000.00 | 1,957,232,901.76 |

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит | | | Аудитын код: |
|------------------------------|--|---|--|---|--------------------------|
| 2020.03.10 | | | | | САГ-2020/92/СТА-ТӨҮГ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт | | | Сая төгрөгөөр | |
| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Санхүүгийн тайланд тусгагдсан он удаан жил болсон 11.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй. | 11.1 | Зөвлөмж | ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралтын дарга, ахлах нягтлан бодогч | Ж.Амарсүрэн, Д.Цэцэгбаяр |
| | Дүн | 11.1 | | | |

